

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо¹ : 2019 оны 02-р сарын 26-ны өдөр
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/201901336

“Монголросцветмет” ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Нowo-5707 маркийн өөрөө буулгагчийн засварт шаардлагатай сэлбэг” нийлүүлэх**– тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэгүй авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **[50 000.00]²** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил (**2016, 2017, 2018 оны жилийн**)-ийн борлуулалтын орлогын жилийн дундаж нь тендерийн төсөвт өртгийн 100 хувиас багагүй.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Үнийн саналын дүнгийн 100 хувиас багагүй.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2016, 2017, 2018 оны жилийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт.**

Тусгай зөвшөөрөл шаардахгүй.

Тендерийн хамт **4 452 000³** төгрөгийн дүнтэй тэнцэх тендерийн баталгаа⁴ ирүүлнэ.

Тендерийг **[2019 оны 03-р сарын 28-ны өдрийн 14:00 цаг]**–аас өмнө www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлэх ба тендерийг **[2019 оны 03-р сарын 28]-ны өдрийн [14:30 цаг]⁵-т** цахим системээр нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэхийг эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрнө.**

Дотоодны давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**[Монголросцветмет” ХХК, УБ,БЗД, Энхтайваны өргөн чөлөө-98
(№305 тоот, утас/факс:450060+243, факс: 458380)]**

-
- 1 Тендерийн урилгыг анх зарлан мэдээлсэн өдөр байна.
 - 2 Тендерийн баримт бичгийг түүнийг бэлтгэхэд буюу хувилж олшруулах, шуудангаар хүргэх зэрэгт зарцуулсан өртгөөр үнэлж, тендер шалгаруулалтад оролцохыг хүсэгчдэд энэ үнээр саадгүй олгоно.
 - 3 Төсөвт өртгийн 1-2 хувьтай тэнцүү байна.
 - 4 Барааны төсөвт өртөг 30 сая төгрөгөөс дээш бол, тендерийн баталгаа ирүүлэхийг заавал шаардана.
 - 5 Тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш 1 цагийн дотор байна.